



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

### Оюутны шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.6, 18.7 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 189 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 621 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Оюутны шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Жүдо бөхийн шигшээ багийн тамирчнаар Мөнх-Эрдэнийн Ууганжаргал, Тэшүүрийн шигшээ багийн тамирчнаар Ялалтын Зоригтбаатар нарыг 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус томилсугай.

2. Оюутны шигшээ багт шинээр элсэн орж буй дээрх тамирчдыг 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс цалинжуулахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

3. Дээрх шигшээ багийн тамирчдын сургалт, дасгалжуулалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг ахлах дасгалжуулагч Ж.Ганзоригт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД